ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2021/63/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум


2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 11
3.Аудитын тайлан ..... 11
3.1. Ерөнхий зүйл ..... 11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... 12
3.4. Материаллаг байдал ..... 13
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга..... 13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... 13
3.6.1 Төсвийн төлөвлөлт..... 13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл ..... 13
3.6.3 Нэмэлт санхүүжилт ..... 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... 14
3.8. Аудитын гол асуудал..... 14
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол..... 15
4. Аудитын илрүүлэлт..... 15
4.1 Залруулсан алдаа ..... 15
4.2 Төлбөрийн акт ..... 15
4.3 Албан шаардлага ..... 15
4.4 Зөвлөмж..... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022 04 25 № 1/6

танай ____________-ны №____________-т

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Б.ШАГДАРСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ө.БАТЖАРГАЛ

015030630

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

### АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8795867.68** | **18795867.68** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8795867.68 | 18795867.68 |
| **354** | **Хангамжийн материал** | 8795867.68 | 18795867.68 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 102700.00 | 102700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5127767.68 | 5127767.68 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3565400.00 | 13565400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1438556627.44** | **1513881038.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1438556627.44 | 1513881038.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1432393832.15 | 1508678260.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1061362009.86 | 1212062009.86 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -228788649.42 | -263937469.92 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 205952900.00 | 175462900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -111175879.58 | -64523966.58 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 575900236.80 | 581307236.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -439481085.77 | -478512445.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45492656.77 | 46532656.77 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19257838.71 | -24963088.24 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 247373067.00 | 247373067.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -16491537.84 | -24737306.76 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 10000000.00 | 18000000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 97772098.00 | 97772098.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -569184.96 | -17462470.92 |
| 39217 | Ном | 4305040.00 | 4305040.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6162795.29 | 5202778.77 |
| 39301 | Програм хангамж | 5837000.00 | 5837000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2276204.71 | -3236221.23 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2602000.00 | 2602000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1447352495.12** | **1532676906.62** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1447352495.12** | **1532676906.62** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1447352495.12 | 1532676906.62 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 747402059.17 | 747402059.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 747402059.17 | 747402059.17 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 685349625.87 | 770674037.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 685349625.87 | 685349625.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 85324411.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14600810.08 | 14600810.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1447352495.12** | **1532676906.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

### АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **700596591.00** | **652045461.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **241393741.00** | **222800000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 241393741.00 | 222800000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 241393741.00 | 10600000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1018204.00 | 600000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 240375537.00 | 10000000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | | 212200000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **459202850.00** | **429245461.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 91982950.00 | 60414361.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 71704100.00 | 48018593.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20278850.00 | 12395768.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 367219900.00 | 368831100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 367219900.00 | 368831100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **511373241.41** | **566721049.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **511373241.41** | **553721049.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 466006301.93 | 543472081.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 231038166.39 | 276948851.52 |
| 210101 | Үндсэн цалин | 231038166.39 | 276948851.52 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27186949.13 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27186949.13 | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27456834.00 | 29775188.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2839234.00 | 3290800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24587200.00 | 26137177.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30400.00 | 347211.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24496011.00 | 25184840.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2398100.00 | 2329900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18870951.00 | 13849572.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2940660.00 | 3386160.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 286300.00 | 74200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 1925668.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 3619340.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 250000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 250000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 2297500.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 2297500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1628000.00 | 3562000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1628000.00 | 3562000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42535044.00 | 27117241.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40987936.00 | 26111400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1440000.00 | 586000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61010.00 | 174600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 16641.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46098.00 | 228600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111415297.41 | 178586460.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22968110.00 | 35429872.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 88447187.41 | 143156588.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45366939.48 | 10248968.38 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 45366939.48 | 10248968.38 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45366939.48 | 10248968.38 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **13000000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 13000000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 13000000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **189223349.59** | **85324411.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **189223349.59** | **85324411.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **460221054.00** | **429845461.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1018204.00** | **600000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1018204.00 | 600000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1018204.00 | 600000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1018204.00 | 600000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4592028[illegible]0.00** | **429245461.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 919829[illegible]0.00 | 60414361.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 71704100.00 | 48018593.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20278850.00 | 12395768.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 367219900.00 | 368831100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 367219900.00 | 368831100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **423971054.00** | **410564461.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4239710[illegible]4.00** | **410564461.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **378604114.52** | **400315492.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228903232.00 | 238170116.75 |
| 210101 | Үндсэн цалин | 228903232.00 | 233909216.75 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 4260900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28815812.52 | 31760806.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19611562.52 | 22367013.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2301061.50 | 2348448.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1840849.57 | 1878758.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 460214.93 | 469689.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46021[illegible]4.00 | 4696897.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2745681[illegible]4.00 | 29775188.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2839234.00 | 3290800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24587200.00 | 26137177.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30400.00 | 347211.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 174489[illegible]8.00 | 23844900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2368100.00 | 2130100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11823918.00 | 9075400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2940660.00 | 4801500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 316300.00 | 97000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 7372000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 368900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 250000.00 | 271600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 250000.00 | 271600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 2987600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 223100.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 2764500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1628000.00 | 3562000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1628000.00 | 3562000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 45051258.00 | 28231009.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 43504150.00 | 27225168.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1440000.00 | 586000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 61010.00 | 174600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 16641.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46098.00 | 228600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29050000.00 | 41712272.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29050000.00 | 41712272.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45366939.48** | **10248968.38** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 45366939.48 | 10248968.38 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45366939.48 | 10248968.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **36250000.00** | **19281000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **36250000.00** | **19281000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **36250000.00** | **19281000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 36250000.00 | 19281000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 13000000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 36250000.00 | 6281000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-36250000.00** | **-19281000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Өв.З-Баян-Улаан ЗДТГ** **СТ-4А**

**АУДИТЛАГДАСН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 747,402,059.17 | 14,600,810.08 | 685,349,625.87 | 0.00 | 1,447,352,495.12 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **747,402,059.17** | **14,600,810.08** | **685,349,625.87** | **0.00** | **1,447,352,495.12** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **747,402,059.17** | **14,600,810.08** | **685,349,625.87** | **0.00** | **1,447,352,495.12** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **747,402,059.17** | **14,600,810.08** | **685,349,625.87** | **0.00** | **1,447,352,495.12** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **747,402,059.17** | **14,600,810.08** | **685,349,625.87** | **0.00** | **1,447,352,495.12** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 85,324,411.50 | 0.00 | 85,324,411.50 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **747,402,059.17** | **14,600,810.08** | **770,674,037.37** | **0.00** | **1,532,676,906.62** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 373952800.00 | 359721131.62 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 373952800.00 | 359721131.62 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 373952800.00 | 359721131.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 242360500.00 | 233909216.75 |
| 210101 | Үндсэн цалин | 242360500.00 | 233909216.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши** | 32718500.00 | 31289146.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23024200.00 | 21895353.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | [illegible]423600.00 | 2348448.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | [illegible]938800.00 | 1878758.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 484700.00 | 469689.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4847200.00 | 4696897.02 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29432900.00 | 29427977.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3290800.00 | 3290800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26142100.00 | 26137177.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21844900.00 | 21844900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2130100.00 | 2130100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7075400.00 | 7075400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4801500.00 | 4801500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 97000.00 | 97000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн уст | 7372000.00 | 7372000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 368900.00 | 368900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 271600.00 | 271600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 271600.00 | 271600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2987600.00 | 2987600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 223100.00 | 223100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2764500.00 | 2764500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4740700.00 | 3716000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4740700.00 | 3716000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө** | 874000.00 | 851841.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432000.00 | 432000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 174600.00 | 174600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38800.00 | 16641.00 |
| 210807 | Газрын төлбөр | 228600.00 | 228600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38722100.00 | 35422850.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3[illegible]722100.00 | 35422850.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Өв.З-Баян-Улаан ЗДТГ НТ-2

АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **60414361.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **60414361.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | **60414361.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 4260900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 4,260,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 471660.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 471,660.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 347211.00 |
| 210302 | Түлш, халаалт | - | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 347,211.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 2000000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 28072968.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 28,072,968.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 11722622.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 11,722,622.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зүүнбаян-улаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил,

тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг 2022.02.23-аас 2022.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.02.25-ний өдрийн 2/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн бодлого шийдвэрийг оновчтой, шуурхай, ил тод, нээлттэй зохион байгуулалтаар иргэдэд хүргэж, сум орноо тогтвортой хөгжүүлэн иргэдийнхээ амьдрал ахуйг дээшлүүлэх эрхэм зорилготой. Төр засгийн бодлого шийдвэрийг оновчтой шуурхай ил тод нээлттэй зохион байгуулалтаар иргэдэд хүргэж Засгийн газар болон аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргатай сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, сумын хөгжлийн төлөвлөгөө, Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчид, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлэн бодлогын зорилт, зорилгуудыг хэрэгжүүлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах чиг үүрэгтэй

Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Татварын Ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбаян-улаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “ Дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 566,721.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,667.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,533.7 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнбаян-улаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,324.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 48,400.0мянган төгрөгийн 2 ширхэг худаг, цэцэрлэгт хүрээлэнгийн сайжруулалтад 50,000.0 мянган төгрөг, наадмын талбайн сайжруулалтад 30,000.0 мянган төгрөг, хадлангийн талбайн өргөтгөл 10,000.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлгийн сайжруулалтад 4,000.0 мянган төгрөг, хүндэтгэлийн самбар 8,000.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр Ланд-105 автомашин зэрэг хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,000.0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материал хуваарилагдсан нь шалтгаалжээ.

Тайлант онд авлага, өглөгт өөрчлөлт ороогүй байна.

Зүүнбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 48,551.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 55,347.8 мянган төгрөгөөр өссөн байна..

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 337,434.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 337,434.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 373,352.8 мянган төгрөгийн төсөв баталж төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 368,831.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 358,582.1 мянган төгрөгийг зарцуулж 10,249.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 48,018.6 мянга төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 12,395.8 мянга төгрөг, нийт 60,414.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Мал т эоллогын зардалд 1,113.8 мянган төгрөг, статистикийн судалгааны урамшуулалд 182.0 мянган төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 26,959.2 мянган төгрөг, үлийн цагаан оготны зардалд 9,500.0 мянган төгрөг, сумын эмнэлгийн автомашинд 13,000.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

## 3.8. Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

## 3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлт эс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зүүнбаян-улаан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроосон 13, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 5 төрлийн 45312.2 мянган төгрөгийн санхүүжилт, 3 төрлийн 25367.0 мянган төгрөгийн зардлыг мэдээлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж, албан шаардлага, акт өгөгдөөгүй байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитын явцад зөрчил илрээгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар байгууллагын үйл ажиллагааны үндсэн данснаас 1042.3 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол зөрчин уралдаан тэмцээний зардалд шилжүүлсэнд 1 албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад үндсэн хөрөнгийн орлогын дүнг ерөнхий журналтай тулган шалгахад 6,281.0 мянган төгрөгөөр буруу бичилт хийж залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт өгөгдөөгүй.

### 4.3 Албан шаардлага

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн данснаас 1042.3 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43-р тогтоол зөрчин уралдаан тэмцээний зардалд шилжүүлсэн байна.

### 4.4 Зөвлөмж

Аудитын явцад зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1. | Зүүнбаян-улаан сумын Засаг даргын Тамгын газар | 2 | 7.3 | 1 | 6.3 | | | 1 | 1.0 | | |
| Дүн | | 2 | 7.3 | 1 | 6.3 | | | 1 | 1.0 | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Зүүнбаян-улаан сумын Засаг | 1 | 70.7 | | | | | 1 | 70.7 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын Тамгын газар | | | | | | | | | | |
| Дүн | | 1 | 70.7 | | | | | 1 | 70.7 | | |
| Нийт дүн | | 3 | 78.0 | 1 | 6.3 | | | 2 | 71.7 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Э.ЭНХБАЯР

2022 ОНЫ 02 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР